

Манмин Мэдээ

№ 71 2019 оны 4 сарын 28

“Илүү их сэргэлт ба хөгжил дэвшил рүү”

И Да манмин чуулганы 25н жилийн ойн баярын үйл ажиллагаа болон Япон дахь пасторууд ба ажилтнуудын сургалт



сургаал заасан юм.

Энэ өдрийн үдээс хойш Ойн баярын мөргөл болон баярын тоглолт өндөр настны халамжийн төв болох “Мичибаса”-н танхимд болсон юм.

Энд Асахикава, Ямагата, Токио, Ёкохама, Мацумото, Нагоя, Осака, Окояма, Окинава зэрэг Японы өнцөг булан бүрээс пасторууд, болон итгэгч нар цуглан талархал болон баяр хөөрөөр илүү нэгдсэн гайхалтай цаг байлаа.

2-р сарын 25нд үдээс хойш И Сү жин пастор И Да Манмин цуглааны байгуулсан өндөр настаны халамжийн төв болох “Мичибаса”-д зочилж, тэнд үйлчилдэг ажилтнуудыг урамшуулан ерөөлийн залбирал хийж өгсөн юм. Үүний дараа Япон дахь пасторууд ажилчдын сургалт И Да манмин чуулганд болсон юм.

И Сү жин пастор өөрийн тухай гэрчлэлтэй хамт “Ерөөлийн сорилт дунд Бурханы сайн хүслийг хайн, өөрийн зүрх сэтгэлээ өргөтгөн, гал мэт халуун залбирдаг сүнслэг дайчид болоод илүү их сэргэлтээр гарч ирэхийг” захиж сургаж байлаа.

Нэг талаар Япон дахь авралын зар тараах суурь болсон И Да манмин чуулган нь Христийн талаар сайн мэдэхгүй япончуудад нийгмийн халамжийн хөтөлбөр чиглэлээр авралын зарыг таниулах боломж нөхцөлийг бүрдүүлсэн юм. И Да хотын халамж үйлчилгээний

төвтэй албан ёсны харилцаа тогтоож, ахмад настнуудын халамжийн ажилд хичээнгүйлэн зүтгэж, хүүхэд залуучуудад зориулсан хөгжим бүжиг вошип зэрэг төрөл бүрийн аргаар авралын зар тарааж байна. Ийм үйл ажиллагаа нь олон нийтийн хэвлэл мэдээлэлээр таниулагдан И Да хотын захиргаанаас талархалын жуух бичиг, И Да хотын даргын шагнал авсан ба И Да манмин чуулган нь энэ мэт өөрийн салбар нэгж “Мичибаса” халамжийн төвөөр дамжуулан Эзэний хайрыг дамжуулан байгаа юм.

Ялангуяа 1994онд И Жей руг тэргүүн пасторын удирдсан ‘И Да бүсийн нэгдсэн их цуглаан’ 1996онд ‘Шинишу бүсийн нэгдсэн их цуглаан’ д хараагүй нүд хараатай болж, сонсголтгүй чих сонсголттой болсон далийж гулзайсан гар хөл тэгширч, алхдаг болсон зэрэг Бурханы агуу эрх мэдэлт хүч Японы бүх нутагт ариун сайн мэдээ тараахад том хувь болсон юм. Мөн 2000онд Нагоя эдгэрэл ивээлийн цуглаанд хэл сонсголын бэрхшээлтэй 13хүн оролцож, ярьж сонсдог болсон нь Бурхан бол амьд оршигч болохыг нотолж өгсөн баталгаанууд үй олноор гарч Япон дахь авралын зар тараах үйлсэд том түлхэц болсон юм.

Одоогийн байдлаар Японд 10салбар сүм, 1хамтарсан сүм, 1гэрийн цуглаан ариун сайн мэдээ тараах үйлсэд зүтгэж байна.

“18жил өвдөж байсан өвчнөөсөө эдгэрлээ”

Би Колумба улсын нийслэлаар Богота хотоос машинаар 1бцаг явж хүрэх Магангүү хотод амьдардаг юм. Енласе телевиз (Испани хэлээр нэвтрүүлдэг Христийн телевиз)-р И Жей руг пасторын сургаалийг сонсож, их ивээл авч Манмин төв сүмд бүртгэгдсэн юм.


Колумба Манмин сүм (хариуцагч Жан Жон ёон пастор) юутүбэ шууд нэвтрүүлгээр Эзэний өдрийн мөргөл ба Лхагва гаригийн мөргөл оролцож, орой болгон Даниел залбирлын цагт хамт оролцдог юм.

Би 18жилийн турш савны үрэвсэлт ургацагын улмаас биеийн юм ирэх тоолонд маш их өвдөлт зовиуртай байв. Түүнчлэн мөн сарын тэмдэг хэт их ирэхээс үүдсэн цус алдалт, ужиг хууч өвчин, ядаргаанаас болж өдөр тутмын амьдрал маш хэцүү өнгөрүүлдэг байлаа. Тэгээд энэ талаар эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх мээ засалд орох хэрэгтэй ч янз бүрийн шалтгааны улмаас ийм зовиур дунд өдөр хоногыг өнгөрүүлж байлаа.

1-р сарын эдгэрэл ивээлийн цуглаанд Юутүбээр оролцож И Жей руг тэргүүн пасторын залбирч өгсөн эрх мэдэлт хүчтэй гар алчуур (Үйлс 19:11-12)-р И Сү жин пасторын залбирал авсаны нэг долоо хоногын дараа биеийн юм ирсэн ба ямар ч өвдөлт зовиургүй, цус алдалт, болон тамирдалт огт мэдрээгүй бөгөөд ингэж энэ өвчнөөсөө эдгэрсэнээ мэдсэн юм.

Саяны 2-р сарын эдгэрэл ивээлийн цуглаанд И Сү жин пастор өвчнүүдийн нэрийг дуудах үед ‘Нурууны өвчин’ гэхэд би “Амеен” гэтэл тэр даруй хүчтэй өвдөж байсан нурууны өвчин алга болсон юм. Сүүлийн үед маш их эрч хүчтэй эрүүл саруул, талархал ба баяр хөөрөөр дүүрэн байна. Халлелүя!

Дейси Патернина
итгэгч (Колумба,
50нас)



Өнгөрөгч 2-р сарын 24, 25нд Есүсийн Ариун урсгалын дэд удирдагч И Сү жин пастор Японд сайн мэдээ тарааж эхэлсэний 25жил И Да манмин чуулганы 25жилийн ойн баяр болон Япон дахь пасторууд, ажилтнуудын сургалт хийхээр явсан юм.

2-р сарын 24нд 10:30 с Япон И Да манмин чуулганы 25жилийн ойн баярын Их мөргөлд төв сүмийн урлагын холбооны харьяа “Power worship” багийн тоглолт түүний дараа үргэлжлүүлэн ‘Сүйт бүсгүйн болзол’ (Матай 25:1-13) гэсэн сэдвээр

Бурханы хүсдэг хайр

“Хэрэв би хүмүүсийн болон тэнгэр элч нарын хэлээр ярьсан ч ... би өөрийн бүх л өмч хөрөнгөө тараан өгч, өөрийн биеийг шатаахаар тушаасан ч надад хайр байхгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм”
1 Коринт 13:1-3.

Манмин Төв сүмийн тэргүүн пастор И Жей руг пастор

Хайрыг мөнхөд хувиршгүй сүнслэг хайр хувирч өөрчлөгддөг махан талын хайр гэж ангилж болох юм. 1 Коринт номын 13-р бүлэгт үзвэл сүнслэг хайрын тухай маш тодорхой тайлбарласан байдаг ба үүнийг тайлбарлахаас өмнө хайрын чухал байдлын тухай онцолсон байдаг.

Бидний зүрх сэтгэлд сүнслэг хайраар дүүрсэн тэр үед л Бурхан Аавыг дуурайсан жинхэнэ үр хүүхэд нь болох учраас юм. Тэгвэл Бурханы хүсэж буй хайр өөрөөр хэлбэл сүнслэг хайрын чухал байдлын талаар үзэцгээе.

1. Амийг өгдөг үр дүнтэй хайр

1-р бүлэг “Хэрэв би хүмүүсийн тэнгэр элчийн нарын хэлээр ярьсан ч надал хайр байхгүй бол би нүргэлэх харанга, хангинах цан болох байсан” гэдэг. Эндээс ‘Хүмүүсийн хэл’ гэж дэлхийн хүмүүсийн хэрэглэдэг бүх хэл яриаг хэлж байгаа бөгөөд ‘Тэнгэр элчийн хэл’ гэж маш уянгалаг үзэсгэлэнтэй хэл яриа гэсэн утгатай. Мөн ус цас шиг ярианы чадвар сайтай хүний яриа юм уу тэнгэр элчийн яриа маш уянгалаг үг яриа байсан ч хайр байхгүй хүнгэнэх харанга, хангинах цантай адил гэсэн үг юм.

Эсрэгээрээ хайр агуулсан ярианд амь амьдрал өгөх агуу хүч байдаг. Есүсийн амьдралаас тэр зүйлийг олж харах боломжтой юм. Нэгэн өдөр Есүс сүмд хүмүүст сургаал зааж байхад, хуулийн багш нар завхайрч байгаад баригдсан нэгэн эмэгтэйд чирэн авчирдаг. Тэгээд “Ийм эмэгтэйчүүд руу чулуу шидэгтүн гэж Мосегийн Хуульд тушаасан. Харин Та юу гэж хэлэх вэ?” (Иохан 8:5) гэж асууцгаав.

Хэрэв Есүс хуулийн дагуу шүү гэвэл эрдийн үед “Дайснаа хайрла” гэдэг сургаалиа Өөрөө зөрчиж байгаа мэт бөгөөд эсрэгээрээ “Уучилж явуул” гэвэл хуулийг зөрчсөн илэрхий том гэм нүгэл болох байлаа. Ингэж занганд оруулах гэсэн тэдний сэтгэлийг сайн мэдэж буй Есүс юу ч ярилгүй доош бөхийн сууж, хуруугаар газарт ямар нэгэн зүйл бичиж эхлэв. Тэгээд цэх зогсоод “Та нарын дундаас нүгэлгүй хүн нь эхлээд энэ эмэгтэй руу чулуу шид гээд” дахин бөхийж газарт бичихэд тэд нар ахмадуудаасаа эхлэн нэг нэгээрээ явсаар Есүс тэр эмэгтэй хоёр л үлдсэн юм (Иохан 8:6-9).

Есүс хуулийг зөрчөөгүй ба тэр эмэгтэйн амийг аварсан юм. Гадна талаар хуулийн багш нар,

фарисайчуудын үг нь Бурханы хуулийн тухай ярьж байгаа нь буруу биш ч тэр үгэнд агуулагдсан санаа нь Есүсийнхээс огт өөрт байсан юм.

Бид ийм Есүсийн сэтгэлтэй бол ‘Ямар үгээр бусдад урам хүч болох вэ?’ гэж залбиран нэг нэг үг бүр бусдад амийг өгөх гэж хичээдэг болох юм. Зарим хүмүүс Бурханы үгээр шууд л бусдыг ятгаж, зэмлэж өөрийн бодолд нийцэхгүй тэрсэлддэг хэсгийг нь засах гэдэг. Хэдийгээр тэр үг зуун хувь үнэн байлаа ч хайр байхгүй бол сонсож буй хүнийг өөрчлөх ч боломжгүй жинхэнэ амийг өгөх ч чадахгүй юм. Үргэлж өөрийгөө эргэн харж, өөрийн зөв байдалд үг хэлж байна уу, үгүй юу гэдгээ мөн хэлсэн үгэнд минь амь өгч чадах хайрын сэтгэл агуулж байгаа юу гэдгээ тунгаах хэрэгтэй юм.

Бусдын төлөө сүнслэг хайр агуулсан нэг үг цангасан сүнсийг тэтгэж, өвдөж шаналж буй сүнсэнд эдгэрлийн баяр хөөр тайтгарал өгдөг амийн ус бөгөөд үнэт эрдэнэс мэт юм.

2. Өөрийгөө зориулах үйлс бүхий хайр

2-р ишлэлд “Хэрэв би эш үзүүлэх чадвартай, мөн бүх нууцууд болон бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр байхгүй бол би юу ч биш.”

Энд хэлж буй ‘Эш үзүүлэх чадвар’ гэдэг нь хэн нэгэнд тусгайлан өгөгдөх Ариун Сүнсний бэлэг бус Есүс Христэд итгэж, үнэн дотор байдаг хэн ч ирээдүйн үйл явдлыг мэдэж ярьж чаддаг талаар хэлж байгаа юм. Библид бичигдсэнчлэн тун удалгүй Эзэн агаар мандалд залран бууж, аврал хүртсэн хүмүүс дээш өргөгдөн 7жилийн хурим найранд оролцох ч, тэгж өргөгдөж чадаагүй хүмүүс нь энэ газар дээр 7жилийн гай гамшигийг туулах болно гэдгийг мэднэ гэсэн үг юм. Энэ мэт ирээдүйд болох үйл явдлыг мэдэж эш үзүүлэх чадвартай ч сүнслэг хайр байхгүй бол өөрийн эрх ашгийн дагуу хувирч өөрчлөгдөх тул ямар ч хэрэггүй гэж байгаа юм.

Мөн ‘Бүх нууц’ гэдэг нь өнө эртнээс далдлагдсан авралын нууц буюу ‘Загалмайн утга учир’-г хэлж байгаа юм (1 Коринт 1:18). Хүн төрөлхтөнийг аврах төлөвлөгөө тул Бурхан үүнийг биелэгдэх цаг үе хүртэл маш чанд нууцалсан юм (1 Коринт 2:6-8). Дайсан сатан диавол нь Адамын гэмийн улмаас өөрт нь дамжуулагдсан эрх мэдлийг мөнх

эзэмших болно гэж бодоод хорон муу хүмүүсийг турхиран Есүсийг загалмайд цовдлуулсан ч ямар гэм зэмгүй Есүсийг хороосноороо харин ч авралыг нээж өгсөн юм. Энэ мэт загалмайн утга учир дахь агуу гайхамшигт нууцыг мэдлээ гээд сүнс талын хайр байхгүй, үүний улмаас бусдад дамжуулахгүй бол ямар хэрэг байх билээ?

Мэдлэг ч мөн адил юм. ‘Бүх мэдлэг’ гэж мэдлэг боловсрол, ухаарал биш Бурханыг мэдэх мэдлэг буюу библийн 66номд агуулагдсан үнэний мэдлэгийг хэлж байгаа юм. Библиэр дамжуулан Бурханыг мэдсэн бол, Бурхантай уулзаж, шууд мэдэрч, зүрх сэтгэлээрээ хүрч, хүлээн аван итгэх хэрэгтэй юм. Толгойгоороо энэ бүхнийг мэддэг төдий бол харин ч эсрэгээрээ энэ мэдлэгээрээ бусдыг дүгнэж, шүүх хэрэгсэл болох эсвэл сайны бус үйлст хэрэглэх гэдэг. Тиймд сүнслэг хайргүй мэдлэг ч юунд хэрэггүй болж байгаа юм.

Түүнчлэн ‘Уулыг нүүлгэх хэмжээний бүх итгэл’ гэж том итгэл ойлгож болох юм. Итгэл нь тэмдэг гайхамшиг зэрэг Бурханы хүч нөлөөг харж мэдэрч байж өсдөг бол, том юмуу эсвэл агуу итгэлтэй гэгдсэн ч хайраар мөн том агуу гэх зүйл биш юм. Сүнс талын хайр нь юуны түрүүнд гэм буруугаа хүлээж хаях, хичээл зүтгэл, золиос гаргах үед л ирдэг зүйл юм. Тиймд ийм сүнс талын хайр байхгүй бол эш үзүүлэх чадвартай байлаа ч, бүх нууц, бүх мэдлэгийг мэддэг байлаа ч, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй ч юу ч биш гэсэн юм.

3. Тэнгэрийн оронд шагнал болох хайр

3-р ишлэлд “Хэрэв би өөрийн бүх л өмч хөрөнгөө тараан өгч, өөрийн биеийг шатаахаар тушаасан ч, надад хайр байхгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм” гэсэн байдаг.

Есүс нь хүмүүсээр магтуулан алдаршуулагдах гэж ил тодоор туслах нь тэнгэрийн орны шагнал болж чадахгүй гэсэн билээ. Хэрэв Бурхан ийм хүнд ерөөл өгвөл өөрийгөө зөвт хүн гэж андууран зүрх сэтгэлдээ хөвч хөндөлтийг ч хийхгүй байх юм. Хүмүүс магтагдах тусам сэтгэл нь өндөр бардам болох ч эцэстээ энэ нь өөрт нь ямар ч ашиггүй юм. Харин эсрэгээрээ хайраас улбаатай тусламж нь хэн нэгэн мэдсэн мэдээгүй хамаагүй хийгддэг. Нууцаар харагч Бурхан Аав үйлдсэний дагуу ерөөл ба шагналаар хариулж өгнө гэдэгт итгэдэг учраас юм (Матай 6:2-4).


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

Тусламж нь юуны өмнө хүмүүсийг тэтгэж тэнхрүүлсэн тусламж байх ёстой бөгөөд Ариун Сүнсний удирдамж дотор бусдад нийцсэн байх ёстой байдаг. Буруу тусламж нь эсрэгээрээ Бурханаас холдуулах эсвэл мөхлийн замруу түлхэх аюултай байдаг. Тийм учраас Бурханы хүсэл дотор хайраар тусламж өгвөл Корнел шиг сүнс сэтгэл сайжирч, бүх зүйл амжилттай болох ерөөл авдаг (Үйлс 10-р бүлэг).

Бурханд өргөх өргөлд мөн адил юм. Марк номын 12-р бүлэгт гардаг нэгэн бэлэвсэн эмэгтэй хэдий хоёр задгай мөнгө өргөсөн ч өөрийн бүх өмч хөрөнгөө ийн өргөсөн тул Есүсийн магтаалийг авсан юм. Харин эсрэгээрээ хүний үгээр болон албадан өргөсөн өргөл нь Бурханыг баярлуулж чадахгүй тул өөрт нь ч үр ашиггүй юм.

Үүнд золиос зориулалт ч мөн адил юм. ‘Өөрийн биеийг шатаахаар тушаасан ч’ гэдэг нь өөрийгөө төгс зориулна гэсэн утгатай. Золиос бол хайраас үүдэлтэй гэх ч хайргүйгээр хичнээн ч золиос гаргаж чаддаг. Ийм хүн бол хэн ч мэдэж ойлгож өгөөгүй бол гоморхож, тэр ч байтугай хичээн зүтгэхгүй хүнийг хараад шүүж дүгнэдэг. Энэ нь алив зүйлд өөрийн үйлс гавъяаг товойлгон магтуулах, зөвшөөрүүлэх сэтгэл болон өөрийгөө итгэмжтэй хийж байгаа гэсэн өргөмжлүүлэх гэсэн сэтгэлтэй холбоотой. Ийм сэтгэл нь тавгүйтэн

бухимдаж өөрийгөө зовоох төдийгүй орчин тойрондоо эв нэгдэл хагалж, Бурханы сэтгэлийг ч өвтгөн хэнд ашиггүй зүйл юм.

Хэдийгээр ил гарган бухимдахгүй ч бусад нь ойлгож өгөхгүй бол сэтгэлээр унаж, эрч хүч сулардаг. Хэн нэгэн зэмлэх эсвэл шүүмжилвэл хүчгүй болж, тэгж хандсан хүнийг эсэргүүцдэг байна. Мөн өөрөөсөө илүүтэй зөвшөөрөгдөн хайрлагдаж байгаа хүнд атаархдаг байна. Тэгээд хичээнгүйлэн хийсэн ч баяр хөөр байхгүй, бүр цаашлаад өөрийн үүрэг албаа хүртэл орхих тохиолдол байдаг.

Удирдах дээд хүн эсвэл бусад хүмүүс харж байхад хичээнгүйлэн зүтгэдэг хүмүүс ч бас байдаг. Хэн нэгэн харахгүй бол залхуурч хойш суун, халыг мулт хийх тохиолдолд бий. Нүдэнд харагдахгүй ажлаас илүү гадна талаас үр дүн нь шууд харагдах зүйлийг хийх гэх мэт эдгээр нь удирдах хүн буюу бусад хүмүүсээс магтаал авах гэсэн сэтгэл байгаа учраас юм.

Тэгвэл сүнслэг итгэлтэй мөртлөө хайр байхгүй золиос гаргадаг учир нь юу вэ? Нэг үгээр хэлэхэд сүнслэг хайр байхгүй учраас юм. Чин сэтгэлээсээ Бурханы юм бол миний юм, миний юм бол Бурханых гэх өөриймсөг сэтгэл байхгүй учраас ийм байдалд хүргэдэг.

Бид жинхэнэ золиос гаргахын тулд юуны

өмнө сүнслэг хайрыг бий болгох хэрэгтэй. Зүрх сэтгэлдээ хайраар дүүрэн хүн хэн нэгэн харсан хараагүй, ойлгож өгсөн өгөөгүй хамааралгүй хийх ёстойгоо л хийсээр байдаг. Есүсийн үйлчлэл ба золиосоор дамжуулан үй олон хүмүүс аврал хүртэнэ гэдэг нь тэр үйлчлэл дотор жинхэнэ хайр байсан учраас юм.

Есүс Бурханыг хайрладаг тул амиа зориулах хүртэл Бурхан хүслийг бүрэн биелүүлсэн юм. Загалмайд цовдлуулах тэр агшинд ч хүн төрөлхтөний төлөө зуучлан залбирч байлаа (Лук 23:34). Ийм жинхэнэ золиосны үр дүнд Бурхан Түүнийг өргөмжилж тэнгэрийн орны хамгийн сүр жавхлантай газарт оруулж өгсөн юм (Филиппой 2:9-11).

Хайрт итгэгч та бүхэн,

Хичнээн өдөр тутмын асуудал шийдэгдэж, бүх зүйл дээр элбэг хангалуун байлаа гээд хайр байхгүй бол амьдралын тэмүүлэл ч байхгүй амьдрах хүсэл ч байхгүй болдог. Энэ мэт хайр нь хүний амьдралд хамгийн чухал хэрэгцээ гэж хэлэхэд хилсдэхгүй биз ээ. Тэгвэл бүр тэр хайр нь хувиршгүй хайр, сүнслэг хайр бол ямар вэ? Бурханы хүсэж буй сүнслэг хайрыг бий болгоод мөнхөд Бурханын баяр хөөр, алдар дотор үргэлж байхыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Жинхэнэ хайрын үлгэр жишээ болсон Сун Ян вон пасторын залбирал

“

“Миний хайртай хоёр хүүг
минь буудаж хороосон нэгнийг
ч гэмшүүлж, өөрийнхөө хүү
болгох хайрын сэтгэл өгсөн
Бурхандаа талархая.”

”

Уяман өвчтэй хүмүүсийн эцэг гэж нэрлэгдэх Сун Ян вон пастор нь уяман өвчтэй хүмүүст бүх сэтгэл зүрхээ зориулсан юм. Японы дарангуйлалын үед тухайн үеийн эрх мэдэлтнүүдийн няцаалт дарамт шахалтын улмаас шоронд хүртэл орж байлаа. Ийм чин сэтгэлийн үйлчлэл дарамтад байсан ч төсөөлж чадахгүй гунигт мэдээ сонссон юм.

1948оны 10-р сарын нэгэн өдөр Ёосү бослого тэмцэлийн үймээн дунд Сун пасторын хоёр хүү (Тун-ин, Тун-шин) нь босогчдын армийн буудалцаан амь үрэгдсэн юм. Жирийн хүн бол “Бурхан минь, Яагаад надад ийм зүйл тохиолдов!” гэж орилж хашгиран гашуудаж, гомдох байсан байх.

Гэтэл Сун пастор харин эсрэгээрээ хоёр хүү нь амиа зориулан Эзэний өвөрт тэврүүлэн Тэнгэрийн оронд очсонд талархаж, бүр цаашлан өөрийнх нь хөвгүүдийг буудсан босогчдын армийн цэргийг хүртэл уучилж, хүүгээ болгон шинэ амьдрал эхлүүлсэн юм. Хөвгүүдийнхээ оршуулгын ёслол дээр Сун пасторын Бурханд өргөсөн 9төрлийн талархалын залбирлыг сонссон хүмүүсийн сэтгэлийг маш их хөдөлгөсөн юм.

1. Над мэт гэмтний мах цусаар амиа зориулагчид үр удмыг төрүүлсэнд баярлалаа.

2. Тоолшгүй олон итгэгчдийн дундаас яаж ийм эрдэнэсүүдийг Эзэн яагаад надад даатгаж өгсөнд талархаж байна.

3. Гурван хүү, гурван охин дундаас хамгийн үзэсгэлэнтэй ууган хүү, удаах хүүгээ зориулах ерөөлийг надад өгсөнд баярлалаа.

4. Нэг хүүгийн амиа зориулалт эрхэм үнэтэй бол тэр тусмаа хоёр хүү минь амиа зориуллаа талархаж байна.

5. Есүст итгэж байгаад хэвтээд үхэх ч том ерөөл бол тэгэх тусам авралын зар түгээж байгаад буудуулж амиа зориуллаа талархаж байна.

6. Америк руу сургуульд явахаар бэлдэж байсан миний хүү, Америкаас илүү сайхан тэнгэрийн оронд очсонд миний сэтгэл амарч байна. Баярлалаа.

7. Миний хайртай хоёр хүүг минь буудсан эсэргүүцэгчийг гэмшүүлж, өөрийнхөө хүү болгох хайрын сэтгэл өгсөн Бурхандаа талархаж байна.

8. Миний хоёр хүүгийн энэ явдлаас болж үй олон тэнгэрийн орны хөвгүүд гарч ирэхэд итгэгдэх учир талархаж байна.

9. Энэ мэт бэрхшээлээс илүү 8-с ч илүү Бурханы хайр ба үнэнийг хайх сэтгэл, өргөн уудам итгэлийг өгсөн Эзэндээ талархалыг өргөө.


Сун Ян вон пастор нь 6-р сарын 25ны дайны үед ч өвчтнүүдээ хамгаалахын тулд байгаа газраасаа дүрвэлгүй эцэстээ коммунист цэргүүдэд баригдан амиа зориулж залуухан 48насандаа амьдралаа төгсгөсөн юм. Хэн ч тоохгүй өвчтнүүдийг хайрлаж, хамгаалан, хөвгүүдийг буудаж хороосон өстөн мэт залууг ч өршөөн хүүгээ болзож, хариу хараагүй золиос гаргаж байгаа түүний сэтгэлд Бурхан болон хүмүүсийн төлөөх жинхэнэ хайр дүүрэн байсан учраас тэр юм.

“Тархины бэртэл ба цус харвалт, Бурханы хайраар маш хурдан эдгэрсэн”

Хо шин гёон сүмд үйлчлэгч
(43нас, 1их бүлэг 8-р хэсэг)



Онош



(Гавал ба тархины байдал) Гавлын ясан дотор доргилтын улмаас үүссэн цус шүүрэлт
(Гадна бэртэлийн байдал) Гавал тархины доргилтын улмаас үүдсэн цус хуралт

2018оны 12-р сарын 25ны автобуснаас буух зуур гутлын өсгий тээглэн шатан дээрээс явган хүний зам руу харуулдан толгойгоороо газар мөргөн унаж, ухаан алдсан юм.

Би түргэний машинаар эмнэлэгт хүргэгдэж, тархины X-гау болон рентген зураг авахуулсан юм. Хариуг нь хүлээх зуур гар утсаараа И Жей руг тэргүүн пасторын өвчин эдгээх залбиралыг автомат хариулагчаар аваад чичирч сандарч байсан минь тайвширсан юм.

Зургийн хариу нь цус алдалт явагдсан байж болзошгүй тул эмнэлэгт хэвтээд тархины MRI болон дэлгэрэнгүй шинжилгээ хийлгэх шаардлагатай байна гэсэн юм. MRI зургийн хариу гарч гавал тархины дотор цус шүүрсэн, гадна талын бэртэлийн улмаас цус хуралттай бдолоо хоног хэвтэж эмчлүүлэх хэрэгтэй гэсэн юм. Ослын дараахан би тэргүүн пасторын залбирал итгэлээрээ авсан учраас Бурхан мэдээж мэс засалд орохоос хамгаалж өгсөн ч эмч маань тархиа хөдөлгөж гэмтээсэн учир хожим янз бүрийн хүндрэл гарч болзошгүй гэсэн юм.

Миний хувьд ингэж тархиа хөдөлгөсөн тул босож суух, алхахад маш зовиуртай дотор муухайран бөөлжиж огиулдаг байлаа. Тэгээд өөрийн амьдралаа эргэн харж махан биеийн бодол санаа, өчүүхэн бодол Бурханы үгийг сахьж чадаагүй зэрэг бүгдийг эргэн санаж гэмшиж, эмнэлэгт эргэлтээ ирсэн пасторууд тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12)-р залбирал авч дотор муухайрч огих мэдрэмж байхгүй болж хоолонд дуртай болсон юм.

Эмнэлэгт хамгийн багадаа 2долоо хоног хэвтэж эмчлүүлэх ёстой гэсэн ч залбирал авсаны дараа бие маань нэлээн дээрдэж, Эзний өдрийн мөргөл ба шинэ он угтах мөргөлдөө оролцох хүсэл дүүрэн байсан юм. Тэгээд би итгэлээрээ эмнэлэгээ гарах хүсэлт гаргахад эмч дахин рентген зураг авч үзээд, өмнөхөөсөө илт дээрдсэнийг хараад ихэд гайхан 12-р сарын 29ны өдөр эмнэлэгээс гарах зөвшөөрөл өгсөн юм. Тэгэхдээ 12-р

сарын 3ны орой Ицагаас эхлэн шинэ оны 1-р сарын 1ны үүрийн 3цаг хүртэл шинэ оноо угтах мөргөлдөө гэртээ харих замд толгой эргэж бие маань зүүн тийшээ хэлбийгээд ганцаараа алхахад хэцүү байсан юм.

Гэсэн ч 1-р сарын 1нд оройн шинэ оны анхны Даниел залбиралд итгэлээрээ явж оролцсон юм. Энэ хугацаанд итгэмжтэй үйлчилж байна гэж гэсэн ч илүү сэтгэл гаргаж чадаагүй байгаад гэмшин, Манмин залбирлын холбооны ахлагчын гар алчуурын залбирал аваад толгой эргэн дайвалзахаа больсон юм.

Тэгээд би тэргүүн пасторын ном “Загалмайн үг” болон гэрчлэлийн ном “Зогсолтгүй”-уншиж анхны сэтгэгдэл баяр хөөрөө алдан, хатуурсан өөрийн итгэлээ эргэн харж, Бурхан Аавтай ойрхон байх ерөөлтэй цаг мөчүүдийг бий болгомогцоо, өдөр бүр Даниел залбиралд оролцон чин сэтгэлээсээ залбирсан юм.

1-р сарын 15ны өдөр И Буг ним ахлагчаа дахин нэг залбирал авсаны дараа толгой өвдөх нь төгс арилж хэвийн болсон юм. Тэгээд 17-ны өдөр эмнэлэгт рентген зураг авахуулж, гавлын ясанд шүүрсэн цус бүрэн шимэгдэж алга болсон байлаа.

Түүнчлэн 1-р сарын 25нд баасан гаригийн 2дах хэсгээр болсон эдгэрэл ивээлийн цуглаанд оролцож, Бурхан миний сэтгэлд хүрч байгааг мэдэрч, И Сү жин пастор гар алчуураар нийтэд нь залбирал хийж өгөхөд бага хэмжээний толгой эргэх зовиур хүртэл бүрэн эдгэрсэн юм. Толгой баруун зүүн тийш, дээш доош нь хөдөлгөж үзэхэд ямарч асуудалгүй байгаагүй бөгөөд одоог хүртэл ямарч зовиур өөрчлөлт байхгүй байсан юм. Ослын дараах бүх муу нөлөө төгс арилж хэвийн болсон юм. Халлелүяа!

Эдгээж өгсөн Бурхан Аавдаа бүх талархал ба алдрыг өргөн, итгэлийг минь сэргээж өгсөн Эзэн болон үргэлж сэтгэлдээ өвөрлөн байгаа тэргүүн пасторгаа баярлалаа.

“60жилийн турш өвдсөн чихний үрэвсэлт өвчнөөсөө эдгэрч одоо сайн сонсдог болсон”

Багадаа усаар тоглож байгаад зүүн чихэндээ ус оруулсан ба түүнээс хойш чихнээс булаг гоождог болсон юм. Чихээ ухахад өвддөг байсан ч үг дуу цөөн ноомой тул зүгээр тэсээд өнгөрдөг байлаа.

Том болоод ч зүүн чихээ ухах гэхэд өвдөөд чихнийхээ эргэн тойрон зөөлөн имэрч маажин, булаг гарвал хөвөнтэй модоор цэвэрлэдэг байлаа. Тэгсээр хэдэн арван жил өнгөрсөөр чих олигтой ухаж цэвэрлэж чадалгүй, дүнгэнэн дүлийрч огт сонсч чадахгүй байсан юм. Гэвч удаан хугацаанд ийм байсан тул дассан тул нээх бухимдах зүйлгүй болсон юм.

Тэгээд 2018оны сүүлээр өнгөрөн одож буй нэг жилээ эргэн харж залбирч байх зуур миний хатуу бодол санаанаас болж эргэн тойрны хүмүүст хэцүү байдал үүсгэж байснаа ухаарч, гэмшсэн сүнс талын ерөөлийн цаг үе байлаа.

Үүний дараахан 2019оны 1-р сарын 2ны өдөр Даниел залбиралд залбирлын ахлагч итгэгч нарынхаа эрүүл мэндийг асуудлыг залбирлын сэдэв болгон өгөн бичлэгээр бэлдсэн тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлыг тавьж өгсөн юм. Тэр өдрөөс хойш миний сэтгэл халуун болж, яагаад ч юм баяртай үйл явдал тохиолдох гэж байгаа юм шиг сэтгэл хөнгөхөн аз

жаргалтай байлаа.

Тэгээд маргааш үдээс хойш 5цагын үед жирийн үед би зүүн чих дүнгэнэвэл гараараа чихээ бөглөх юм уу чихнийхээ омогноос татдаг зуршилтай ба тэр өдөр чихний дэлбэнд ямар нэгэн юм баригдсан юм. Аваад үзтэл 1см орчим хэмжээтэй гонзгойвтор хав хар өнгөтэй чихний хулхи шиг байсан ба бас 2хэсэг жижиг юм гарч ирсэн байв.

Тэр өдрөөс хойш гайхалтай нь чих маань сайн сонсож, би зүүн чихээ ухах үзэхэд огт өвдөхгүй болсон байлаа. Өмнө нь баруун чихээ гараараа таглахад зүүн чихнээс ‘Өүн..’ гэх дуу гардаг байсан бол одоо шалгаад үзтэл огт тийм дуу гарахгүй болсон ба цаг хугацаа өнгөрөх тусам зүүн талын чих сайн сонсдог болсон юм.

60жилийн чихний асуудалыг минь тэр дор нь эдгээж өгсөн сайн Бурхан Аавдаа, хайрын Эзэндээ бүх талархал алдрыг өргөө. Халлелүяа!

Залбирал авсаны дараа чихнээс гарсан хулхи



Паг Ёон хи халамжлагч
(67нас, 1их бүлэг 4-р хэсэг)

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminnews@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин